

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/216
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-
ӨНДӨР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Б.БЯМБАСҮРЭН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань-Өндөр сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 15,039.1 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 20,865.1 мянган төгрөгийн эмийн шууд худалдан авалт хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 97.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх

үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>119,879,146.42</u>	<u>121,015,694.89</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,033,215.53	15,039,073.80
3121	Төгрөг	3,033,215.53	15,039,073.80
31211	Төрийн сангийн харилцах	3,033,215.53	15,039,073.80
33	АВЛАГА	37,780,325.38	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	63,363.38	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	32,234,500.00	00.00
335	Бусад авлага	5,482,462.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	5,482,462.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,065,605.51	105,976,621.09
351	Түүхий эд материал	47,340,192.51	55,431,366.53
35110	Тусгай зориулалттай материал	2,768,227.15	00.00
35130	Эм боох материал	44,571,965.36	55,431,366.94
354	Хангамжийн материал	31,545,413.00	50,545,254.15
35410	Бичиг хэргийн материал	741,240.00	1,398,000.00
35420	Аж ахуйн материал	1,866,650.00	2,823,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	500,000.00	500,000.00
35440	Түлш, шатах тослох материал	8,760,000.00	9,255,000.00
35450	Хүнсний материал	2,272,758.00	7,469,837.00
35460	Бусад хангамжийн материал	17,404,765.00	29,098,567.15
35470	Мал амьтад	180,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>639,617,550.99</u>	<u>752,464,009.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	639,617,550.99	752,464,009.54
392	Биет хөрөнгө	624,597,821.82	737,856,280.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	547,521,050.00	559,521,050.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53,563,851.33	-76,370,286.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,169,219.00	118,607,219.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,141,562.39	-39,025,036.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	124,905,238.56	185,228,468.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,746,644.34	-41,116,797.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,765,260.00	39,667,782.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,327,554.03	-8,656,118.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-983,333.65	-1,000,000.00
393	Биет бус хөрөнгө	15,019,729.17	14,607,729.09
39301	Програм хангамж	1,099,000.00	1,099,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-269,270.83	-681,270.91
39303	Бусад биет бус хөрөнгө	14,190,000.00	14,190,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>759,496,697.41</u>	<u>873,479,704.43</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>759,496,697.41</u>	<u>873,479,704.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	759,496,697.41	873,479,704.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	613,708,592.00	613,708,592.00
51101	Өмч: - төрийн	613,708,592.00	613,708,592.00

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	95,413,035.62	209,396,042.64
51210	Өмнөх үеийн үр дүн	95,413,035.62	95,413,035.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	113,983,069.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,375,069.79	50,375,069.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	759,496,697.41	873,479,704.43

СТ-2А

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	685,687,157.06	821,205,923.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	238,812,117.06	190,172,533.60
120	Нийтлэг татварын бус орлого	238,812,117.06	190,172,533.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	238,812,117.06	190,172,533.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,812,117.06	190,172,533.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	123,214,740.00	631,033,390.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,660,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,065,700.00	1,169,000.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	83,700.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,982,000.00	1,169,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,932,800.00	43,907,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,932,800.00	43,907,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22,216,240.00	585,957,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,216,240.00	585,957,190.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	628,237,277.91	715,761,485.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	628,237,277.91	715,761,485.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	603,937,277.91	715,277,225.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,210,429.00	394,038,088.08
210101	Үндсэн цалин	272,210,429.00	243,517,800.38
210102	Нэмэгдэл	00.00	88,418,820.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	00.00	32,171,602.84
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	29,929,864.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,923,619.01	45,898,361.72
210201	Тэтгэврийн даатгал	25,325,310.85	31,788,586.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,722,104.23	3,670,123.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,177,682.78	2,936,098.51
210204	Ажилгүйдлийн даатгал	422,862.07	730,380.10
210205	Эрүүл мэндийн даатгал	4,275,659.08	6,773,174.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,200,550.00	22,820,740.78

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	4,003,450.00	5,500,000.00
210302	Түлш, халаалт	9,152,000.00	16,505,000.00
210303	Цэвэр, бохир ус	45,100.00	815,740.78
2104	Хангамж, бараа материалын зардал	39,561,565.17	38,929,748.53
210401	Бичиг хэрэг	1,439,150.00	2,533,780.00
210402	Тээвэр, шатахуун	12,199,380.00	25,293,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,274,966.67	3,391,400.00
	Ном, хэвлэл	80,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,436,068.50	7,530,918,653
	Бараа материал акталсны зардал	132,000.00	180,000.00
2105	Нормативт зардал	201,362,422.44	98,897,700,622
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	185,909,957.44	87,586,879.22
210502	Хоол, хүнс	9,172,465.00	11,310,821.00
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,280,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,893,300.00	16,920,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,893,300.00	16,920,300.00
2107	Томилолт, зочны зардал	616,000.00	2,431,700.00
210702	Дотоод албан томилолт	616,000.00	2,431,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,339,600.00	11,968,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,500.00	8,682,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	1,260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	155,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	49,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	41,500.00
210807	Газрын төлбөр	120,000.00	170,000.00
	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,122,100.00	1,610,510.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,829,792.29	74,841,493.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,959,250.00	7,307,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,870,542.29	67,533,993.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,300,000.00	484,259.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,300,000.00	150,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,300,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	150,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	334,259.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	334,259.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>57,449,879.15</u>	<u>113,983,007.02</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	37,500.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	37,500.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-37,500.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>57,412,379.15</u>	<u>113,983,007.02</u>

СТ-3А

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	628,570,810.00	663,267,890.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	628,570,810.00	663,267,890.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	32,234,500.00
1200045	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	32,234,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,570,810.00	631,033,390.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	439,244,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130,878,000.00	1,169,000.00
131103	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	125,700.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	130,752,300.00	1,169,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,618,900.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,701,800.00	43,907,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,701,800.00	43,907,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,747,010.00	585,957,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,747,010.00	585,957,190.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	615,637,594.47	611,097,861.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,637,594.47	611,097,861.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,337,594.47	610,613,602.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,591,804.50	394,030,212.86
210101	Үндсэн цалин	214,373,000.00	243,509,925.16
210102	Нэмэгдэл	78,730,100.00	88,418,820.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	58,556,504.50	32,171,602.84
210105	Гэрээт ажлын хөлс	28,932,200.00	29,929,864.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,309,272.30	45,834,998.34
210201	Тэтгэврийн даатгал	33,139,143.30	31,194,895.80
210202	Тэтгэмжийн даатгал	3,792,556.50	3,670,123.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,034,026.80	2,936,098.46
210204	Ажилгүйдлийн даатгал	758,531.70	730,380.10
210205	Эрүүл мэндийн даатгал	7,585,014.00	7,303,500.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,650,000.00	23,315,740.78
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	5,500,000.00

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	17,000,000.00	17,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,150,000.00	815,740.78
2104	Хангамж, бараа материалын зардал	31,540,966.67	41,347,843.53
210401	Бичиг хэрэг	2,612,800.00	4,064,250.00
210402	Тээвэр, шатахуун	19,124,200.00	24,286,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,089,966.67	3,391,400.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	4,835,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,714,000.00	4,769,393.53
2105	Нормативт зардал	78,453,451.00	62,955,867.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,799,841.00	43,447,967.00
210502	Хоол, хүнс	10,653,610.00	16,507,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,572,000.00	21,288,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,320,200.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	4,051,800.00	13,288,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,329,000.00	2,431,700.00
210702	Дотоод албан томилолт	1,329,000.00	2,431,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,681,900.00	12,101,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	634,400.00	8,679,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	1,260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	24,000.00	155,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,500.00	49,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	41,500.00
210807	Газрын төлбөр	120,000.00	170,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	1,746,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,209,200.00	7,307,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,209,200.00	7,307,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,300,000.00	484,259.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,300,000.00	150,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,300,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	334,259.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	334,259.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,933,215.53</u>	<u>52,170,028.27</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,900,000.00	40,164,170.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,900,000.00	40,164,170.00

2200	Дотоод эх үүсвэрээр	9,900,000.00	40,164,170.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,900,000.00	40,164,170.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,900,000.00	-40,164,170.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,033,215.53	12,005,858.27
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	3,033,215.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,033,215.53	15,039,073.80

СТ-4А

2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	599,518,592.00	4,490,974.74	-116,265,051.35	487,744,515.39
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,518,592.00	4,490,974.74	-116,265,051.35	487,744,515.39
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	613,708,592.00	50,375,069.79	95,413,035.62	759,496,697.41
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,708,592.00	50,375,069.79	95,413,035.62	759,496,697.41
D08	Тайлант үеийн үр дүн		00.00	113,983,007.02	113,983,007.02
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,708,592.00	50,375,069.79	209,396,042.64	873,479,704.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	667,450,415.53	650,927,772.51	16,522,643.02	97.5
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	667,450,415.53	650,927,772.51	16,522,643.02	97.5
210	Бараа, үйлчилгээний зардал	667,300,415.53	650,777,772.51	16,522,643.02	97.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,020,100.00	394,030,212.86	8,989,887.14	97.8
210101	Үндсэн цалин	243,957,100.00	243,509,925.16	447,174.84	99.8
210102	Нэмэгдэл	85,538,400.00	88,418,820.36	-2,880,420.36	103.4
210104	Урамшуулал	40,937,500.00	32,171,602.84	8,765,897.16	78.6
210105	Гэрээт ажлын хөлс	32,587,100.00	29,929,864.50	2,657,235.50	91.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,154,800.00	45,834,998.34	319,801.66	99.3
210201	Тэтгэврийн даатгал	31,385,100.00	31,194,895.80	190,204.20	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,692,500.00	3,670,123.00	22,376.91	99.4
210203	ҮОМШӨ ний даатгал	2,954,000.00	2,936,098.46	17,901.54	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	738,500.00	730,380.10	8,119.90	98.9
210205	Эрүүл мэндийн даатгал	7,384,700.00	7,303,500.89	81,199.11	98.9

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,650,000.00	23,315,740.78	334,259.22	98.6
210301	Гэрэл цахилгаан	5,500,000.00	5,500,000.00		100
210302	Түлш, халаалт	17,000,000.00	17,000,000.00		100
210303	Цэвэр, бохир ус	1,150,000.00	815,740.78	334,259.22	70.9
2104	Хангамж, бараа материалын зардал	43,215,115.53	42,114,213.53	1,100,902.00	97.5
210401	Бичиг хэрэг	3,125,000.00	4,064,250.00	-939,250.00	130.1
210402	Тээвэр (шатахуун)	25,701,100.00	24,286,900.00	1,414,200.00	94.5
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,391,400.00	3,391,400.00		100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,835,900.00	4,835,900.00		100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	6,161,715.53	5,535,763.53	625,952.00	89.8
2105	Нормативт зардал	67,128,900.00	62,955,867.00	4,173,033.00	91.2
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	47,621,000.00	43,447,967.00	4,173,033.00	93.8
210502	Хоол, хүнс	16,507,900.00	16,507,900.00		100
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,000,000.00	3,000,000.00		100
2106	Эд хогшил худалдан авах	61,676,300.00	60,686,100.00	990,200.00	98.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,397,800.00	24,397,800.00		100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	8,990,200.00	8,000,000.00	990,200.00	89
210604	Урсгал засвар	13,288,300.00	13,288,300.00		100
2107	Томилолт, зочны зардал	2,431,700.00	2,431,700.00		100
210702	Дотоод албан томилолт	2,431,700.00	2,431,700.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,705,600.00	12,101,440.00	604,160.00	95.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,113,200.00	8,679,000.00	434,200.00	95.2
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,260,000.00	1,260,000.00		100
210803	Даатгалын үйлчилгээ	49,300.00	49,300.00		100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,500.00	41,500.00		100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	41,500.00	41,500.00		100
210806	Мэдээллийн технологийн зардал				
210807	Газрын төлбөр	170,000.00	170,000.00		100
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,916,500.00	1,746,550.00	169,950.00	91.1
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	7,317,900.00	7,307,500.00	10,400.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,317,900.00	7,307,500.00	10,400.00	99.9
	Урсгал шилжүүлэг	150,000.00	150,000.00		100
	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00	150,000.00		100

	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	150,000.00	150,000.00		100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	633,333,915.53	665,966,846.31	-32,632,930.78	105.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,907,200.00	43,572,940.78	334,259.22	99.2
132001	Орон нутгийн төсвөөс	43,907,200.00	43,572,940.78	334,259.22	99.2
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	552,990,000.00	585,957,190.00	-32,967,190.00	106
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	552,990,000.00	585,957,190.00	-32,967,190.00	106
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,267,715.53	35,267,715.53		100
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,234,500.00	32,234,500.00		100
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,169,000.00	1,169,000.00		100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,033,215.53	-3,033,215.53	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15,039,073.80	-15,039,073.80	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00	-	100
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Чандмань-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 05-ны өдрийн А/06 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 заалт бүхий 3 ажлын төлөвлөгөө гаргаж хяналт шалгалтыг зохион байгуулж дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. Тухайлбал: Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

¹ “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

² “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,4 сая төгрөгөөр буюу 6,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,033.2	15,039.1	-12,005.9
Авлага	37,780.3	0	-37,780.3
Бараа материал	79,065.6	105,976.6	-26,911.0
Үндсэн хөрөнгө	639,617.6	752,464.1	112,846.6
Нийт хөрөнгө	759,496.6	873,479.7	-113,983.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	759,496.6	873,479.7	-113,983.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	759,496.6	873,479.7	-113,983.1

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 12,005.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 26,911.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 112,846.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 180,380.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 40,164.2 мянган төгрөгийн

худалдан авалт хийж, 140,216.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй буюу улсын төсөв, орон нутгийн төсвөөс машин тоног төхөөрөмж авсантай холбоотой байна.

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 32,345.5 мянган төгрөгийн авлага хаагдсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал 585,957.2 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 43,572.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийт зарлагыг 629,530.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хангамж бараа материалын зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр бууруулж, 585,957.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 3,000.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 585,957.2 мянган төгрөгийг Орон нутгийн урсгал санхүүжилтээс үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 585,957.2 мянган төгрөг, Орон нутгийн орлогоос 43,572.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 650,927.6 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 16,522.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	314,519.0	305,604.5	8,914.5	97.2%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	272,587.5	265,313.5	7,274.0	97.3%
3	Дээд шатны төсвөөс хувиарласан	36,436.7	36,436.7	0	100.0%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	30,650.0	30,315.7	334.3	98.8%
5	Нийтлэг үйлчилгээ	13,257.2	13,257.2	0	100.0%
	Дүн	667,450.4	650,927.6	16,522.8	98.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 37,780.3 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Чандмань-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 628,237.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,564.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 8,795.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 44,135.7 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 19,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, орлого илүү мэдээлсэн 48,251.5 мянган төгрөгийн 5 гүйлгээ нийт 111,387.2 мянган төгрөгийн 10 гүйлгээг илүү дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуультай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Чандмань-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд ёзавсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага өгөөгүй, Чандмань өндөр эрүүл мэндийн төв нь хуучин нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгааг сумын эрүүл мэндийн төв нэртэй улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авах, Монос хөвсгөл ХХК-д 5,500.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийг авлага үүсгэсэн 2 зөвлөмж өгсөн ба биелэлтийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,500.00	2	5,500.00	100
Нийт дүн	2	0	2	5,500.00	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 20,865.1 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 168,754.2 мянган төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 45,177.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 123,576.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 37,716.9 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 7,460.4 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 123,576.9 мянган төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 123,576.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалыг түүвэрлэн тулгахад нийт 10,779.0 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7⁵ гэсэн заалттай нийцээгүй ба “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 1,410.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁵ "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 44,135.7 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 19,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, орлого илүү мэдээлсэн 48,251.5 мянган төгрөгийн 5 гүйлгээ нийт 111,387.2 мянган төгрөгийн 10 гүйлгээг илүү дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	37,716.9			1	37,716.9	1	37,716.9				
эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	7,460.4			1	7,460.4	1	7,460.4				
Дүн	2	45,177.3			2	45,177.3	2	45,177.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримт дутуу	1	10,779.0					1	10,779.0				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	1,410.7					1	1,410.7				
Дүн	2	12,189.7					2	12,189.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй	1	44,135.7					1	44,135.7
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй		48,251.5					0	48,251.5
Орлогын гүйлгээг илүү мэдээлсэн	0	48,251.5					0	48,251.5
Дүн	1	111,387.2					1	111,387.2

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТЫН ТАЙЛАНГ:



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

